Зэвсэгт хүчний Жанжин штабын Ёс зүйн дэд
хорооны 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн
01/3898 дугаар албан бичгийн хавсралт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ, ТӨРЛИЙН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ, УДИРДАХ ГАЗАР, ХАРЬЯА НЭГТГЭЛ, АНГИ, БАЙГУУЛЛАГЫН "ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО"-НЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг.Товч танилцуулга
ЗХЖШ-ын даргын 2025 оны "Зэвсэгт хүчний Жанжин штабын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай" А/120 дугаар тушаалаар томилогдсон ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хороо нь 2025 оны төлөвлөгөөндөө "Зэвсэгт хүчний алба хаагчдын ёс зүйн төлөвшил, харилцаа хандлагыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, алба хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх" зорилго тавин ажилласан. Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг мөрдлөг болгон тусгай төлөвлөгөөгөөр үйл ажиллагааг хангаж байна. Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулж, Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг мөрдлөг болгон тусгай төлөвлөгөөгөөр үйл ажиллагааг хангаж байна. Төлөвлөгөөнд "Алба хаагчдын ёс зүйн төлөвшил, харилцаа хандлагыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, алба хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлэх" зорилгыг дэвшүүлж, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, хуралдааныг зохион байгуулах, тайлагнах, мэдээлэх арга хэмжээний хүрээнд 5, ёс зүйг сахиулах чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлж, хяналт тавих, гомдол мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх арга хэмжээний хүрээнд 3, соён гэгээрүүлэх буюу ёс зүйн сургалт, үнэлгээ, дүгнэлт өгөх, үүрэг даалгавар, зөвлөмж өгөх арга хэмжээ зэрэг, нийт 12 ажил, арга хэмжээний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн дүнгээр 98.3 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнаж байна.
Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт
Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу ЗХЖШ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх талаар "Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, цэргийн алба хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх", "Цэргийн алба хаагчдын хандлага, ёс зүй, хандлага, хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах", "Зэвсэгт хүчний хэмжээнд байгууллагын соёлыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх" ажлыг зохион байгуулж, гүйцэтгэл 100%-тай хэрэгжүүлж, тайлагнасан байна.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал
УИХ-ын байнгын хорооны 2021 оны "Зөвлөмж, чиглэл өгөх тухай" 02 дугаар албан зөвлөмжийн дагуу Дэд хороод нь зүй бус үйлдлийг таслан зогсоох, шаардлагатай арга хэмжээг эрхлэх ажил, үүргийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж, Монгол Улсын Их Хурлын

2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр" (2024-2030)-ийн хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэн ажилласан.

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд төрийн албан хаагч нь бусадтай зүй бусаар харилцах, гутаан доромжлох, нэр хүндэд халдах, хамт олны нэгдмэл байдлыг алдагдуулах үйлдэл гаргахгүй байх, ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэхэд чиглэсэн ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Иргэд, цэргийн алба хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 17 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын цэргийн нийтлэг дүрэм", Батлан хамгаалахын сайдын 2014 оны А/20 дугаар тушаалаар батлагдсан "Батлан хамгаалах яаманд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам", ЗХЖШ-ын даргын 2019 оны А/363 дугаар тушаалаар батлагдсан "Зэвсэгт хүчний Жанжин штабын хөдөлмөрийн дотоод журам"-ыг тус тус удирдлага болгон ажиллаж байна.

ЗХЖШ, төрлийн цэргийн командлал, барилга-инженерийн цэргийн удирдах газар, харьяа нэгтгэл, анги, салбар, байгууллагад 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар иргэдээс 3903 өргөдөл, гомдол ирүүлснээс 3673 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хэрэгжилт 94% хувьтай байна.

Шийдвэрлэхээр хуулийн хугацаандаа хянагдаж, хүлээгдэж байгаа 230 өргөдөл байгаагаас ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол бүртгэгдээгүй байна.

2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Тайлангийн хугацаанд ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хороо нийт 2 удаа хуралдаж, холбогдох шийдвэрийг гаргаж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тодотгож ажилласан.

Дэд хорооны хуралдаанаар ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналын танилцуулгыг ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд танилцуулж, цаашид дараах арга хэмжээнд анхаарч ажиллахад дэд хорооны гишүүд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан. Үүнд:

-ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

-Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлыг чанартай зохион байгуулж, нөлөөллийн арга хэмжээг зохион хэрэгжүүлэх;

Цэргийн төв хэвлэл "Соёмбо" сонинд соён гэгээрүүлэх, ёс зүйн мэдлэг олгохтой холбоотой мэдээллийг нийтлүүлэх;

-Сургалтыг танхимын болон цахимаар үр дүнтэй явуулж, дүгнэх;

-Ёс зүйн дэд хороодтой цахим хаяг үүсгэн бүх төрлийн мэдээлэл, үйл ажиллагааны талаар мэдээллийг түргэн шуурхай солилцож байх;

-Хяналт, шалгалтаар үүрэг гүйцэтгэхдээ ёс зүйн чиглэлээр хяналт, шалгалтыг зохион байгуулж, дүгнэх;

-Дараагийн төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээнд бие даасан сургалтыг зохион байгуулах, түүнд хяналт тавих тал дээр анхаарах;

-Зэвсэгт хүчний Ёс зүйн дэд хороодын томилгоот алба хаагчдын томилгоо, судалгааг авах, ёс зүйн чиглэлийн мэдээлэлд анхаарах зэрэг үүргийг гишүүдэд өгсөн.

Энэ хуралдаанаар Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны "Тогтоол хүргүүлэх тухай" 1/226 дугаар албан бичгийг танилцуулан ажилласан.

ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны даргын 2025 оны "Тайлан ирүүлэх тухай" 02/2964 дүгээр албан бичгээр ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, төрлийн цэргийн командлагч, удирдах газрын даргад алба үүргийг хүргүүлж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх чиглэлээр анги, байгууллагын "Ёс зүйн дэд хороо"-ны улирал, хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг /www.ec.gov.mn маягтын дагуу улирал бүрийн сүүлийн сарын хоёрдугаар долоо хоногт, хагас жилийн тайланг 06 дугаар сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 20-ны ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хороонд хаяглан бичгээр болон цахимаар ирүүлэхийг үүрэг болгон хяналт тавин ажилласан.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, нэгтгэл, анги, салбарын Ёс зүйн дэд хорооны ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах ажил, арга хэмжээний хүрээнд зохион байгуулах Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн бие бүрэлдэхүүнтэй зохион байгуулах ёс зүйн сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн бие бүрэлдэхүүнтэй зохион байгуулах ёс зүйн сургалтын хөтөлбөр, сэдэв" болон "Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн ёс зүйн дэд хорооны чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр"-ийг тус тус боловсруулж, "Ёс зүйн үндсэн ойлголт, зарчим, байгууллага, хувь хүний үнэт зүйлсийг ойлгуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд ёс зүйг хэрэгжүүлэх, мэдлэг, дадлага эзэмшүүлэх" зорилгын хүрээнд 4 цагийн, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн ёс зүйн дэд хорооны чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Ёс зүйн дэд хорооны чадавх, манлайллыг бэхжүүлж, ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх, цэргийн өдөр тутмын үйл ажиллагаанд ёс зүйг хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг нэмэгдүүлж, байгууллагын соёлыг сайжруулах" зорилгын хүрээнд 4 цагийн, нийт 8 цагийн хичээлийн конспектийг боловсруулж, цахимаар хүргүүлж, ЗХЖШ-ын даргын 2025 оны "Ёс зүйн сургалтыг зохион байгуулж, дүгнэх тухай" А/581 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, дүгнэж ажилласан. Энэхүү арга хэмжээний хэрэгжилт нь 2026 оны I улирлын хэрэгжилтээр нэгтгэж, дүгнэн урамшуулал, хариуцлагын арга хэмжээг ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны хуралдаанаар хэлэлцэхээр төлөвлөсөн.

"Төрийн албаны сахилга, хариуцлагыг чангатгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Батлан хамгаалахын сайдын 2025 оны 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд ёс зүйн чиглэлээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг ханган, сар бүр тайлагнаж ажилласан.

ЗХЖШ-ын даргын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/520 дугаар тушаалаар томилогдсон 4 бүлэг 2025 оны 22-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд төрлийн цэргийн командлал, удирдах газар, 28 анги, байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамж"-ийн 2.2.1-д заагдсан Төв комиссын даргын бэтэлсан шалгуур үзүүлэлт, аргачлалын дагуу шалган туслах ажлыг зохион байгуулахад Ёс зүйн талаар хийж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, дэд хороодын үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг зохион байгуулж, үнэлгээ, дүгнэлт өгсөн.

Гарсан үр дүн, ололт, амжилт	Бэрхшээл

Төрийн албаны үйл ажиллагаанд ёс зүйн хэм хэмжээ, холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн шаардлагыг баримтлан иргэдийн санал, хүсэлт, уулзалтын үед эелдэг боловсон харьцааг эрхэмлэн, адил тэгш хандаж, хүнд суртал гаргалгүй хуулийн хүрээнд асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж үйлчлэх талаар шат дараалсан арга хэмжээг зохион байгуулсан. Монгол Улсын Хурлын 2024 оны “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 27 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 258 дугаар тогтоол “Төрийн албан хаагчдын сахилга, дэг журмыг бэхжүүлэх” 01 дүгээр албан даалгавар, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/336, 2021 оны А/71, А/83 дугаар тушаал, ЗХЖШ-ын даргын 2017 оны А/535 дугаар тушаал, удирдлагын тушаал, шийдвэр, албан даалгавар, зөвлөмж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбарууд зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар 2025 оны ахлах офицерын жил болгон зарласантай холбогдуулан командлалын “Ахлах офицер”-уудын идэвх оролцоог хангах зорилгоор бие бүрэлдэхүүний ёс зүй, харилцаа хандлагад нөлөөлөх, үлгэрлэн дуурайх, бахархах үзлийг төрүүлэх сарын аяныг 2025 оны 08-09 дүгээр саруудад зохион байгуулсан. Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж буй сургалтыг мэдээллийн цагаар явуулж, холбогдох хууль тогтоомжийг судлуулсан. Хувь хүний соёл, харилцааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх уриа, баннер, холбогдох бусад мэдээллийг Зэвсэгт хүчний цахим хаалттай групп,	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 1.5, 3 дугаар зүйлийн 3.8.5 дахь заалтууд зарим талаар хэрэгжихгүй, Зэвсэгт хүчний хэмжээнд Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн урамшууллыг төсөвт тусгуулан олгогдохгүй байна.

штаб, салбарын мэдээллийн самбаруудад байрлуулж, ёс зүйн дүрэм, хүний эрхийн түгээмэл асуудлуудтай холбоотой мэдээ, зурагт мэдээллүүдийг хүргүүлж, сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг сар бүрийн 25-ны өдөр Зэвсэгт хүчний Жанжин штабт нэгтгэн ажиллаж хэвшсэн. Зэвсэгт хүчний хэмжээнд цэргийн алба хаагчдын ёс зүйн андгайг улирал бүр өргүүлж хэвшсэн.	
Санал	
1.Зэвсэгт хүчний хэмжээнд Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийн урамшууллыг төсөвт тусгуулан олгуулах; 2.Зэвсэгт хүчний алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулахад шаардлагатай төсвийг шийдвэрлэх.	

Шалгах хэсэг:

☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:
Ёс зүйн дэд хорооны дарга:
ЗХЖШ-ЫН НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ ДАРГА, ЗХЖШ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
.....
(Албан тушаал) ..... (Гарын үсэг) ..... (Гарын үсгийн тайлал)

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга:
ЗХЖШ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
.....
(Албан тушаал) ..... (Гарын үсэг) ..... (Гарын үсгийн тайлал)

БАТЛАВ
ЗХЖШ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА, ЗХЖШ-ЫН
НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ ДАРГА
БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ж.ӨСӨХБАЯР

2025 оны 02 дугаар сарын 21-ны өдөр

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗОРИЛГО: Зэвсэгт хүчний алба хаагчдын ёс зүйн төлөвшил, харилцаа хандлагыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх.

№	Гүйцэтгэх ажил, арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга зам	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Харилцан ажиллах байгууллага, нэгж
1	2	3	4	5	6
Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар					
1	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж, дүгнэх	2025 оны 04 дүгээр сар	Хурандаа А.Нямбаяр	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
2	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны хуралдааны бэлтгэлийг хангаж, дэгийн дагуу хуралдуулах	Хуралдааны дэг, танилцуулгыг боловсруулан бэлтгэлийг хангаж, хуралдааныг зохион байгуулах	Тухай бүрт	Бригадын генерал Ж.Өсөхбаяр Хурандаа А.Нямбаяр	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд
3	ЗХЖШ-ын газар, хэлтсийн дарга, Төрлийн цэргийн командлагч, удирдах газрын дарга, нэгтгэл, анги, салбарын захирагч нараас алба хаагчийн ёс зүйн талаар гаргасан санал, дүгнэлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Гаргасан санал, дүгнэлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх	Тухай бүрт	Бригадын генерал Ж.Өсөхбаяр Хурандаа А.Нямбаяр	ЗХЖШ-ын бүтцийн нэгж, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, салбар

1	2	3	4	5	6
4	Иргэн, цэргийн алба хаагч, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг гаргаж, холбогдох байгууллага, газар, хэлтэст хүргүүлэх	Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, шийдвэрлэлтийн тайлан мэдээ гаргаж, холбогдох байгууллага, газар, хэлтэст хугацаанд нь хүргүүлэх	Жилдээ	Бригадын генерал Ж.Өсөхбаяр Хурандаа А.Нямбаяр	ЗХЖШ-ын ЗУГ-ын Хуулийн хэлтэс
5	Ёс зүйн хорооны үйл ажиллагааны баримт бичгийг архивын нэгж үүсгэж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Баримт бичгийн архивын нэгж үүсгэж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	12 дугаар сар	Хурандаа А.Нямбаяр	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүд
Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд:					
1	Ёс зүйн хорооны хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллах	Хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Жилдээ	Хурандаа А.Нямбаяр	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүд
2	Алба хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх	Гомдол, мэдээллийг хүлээн авч, тайлбар, нотлох баримтыг цуглуулан шалгах	Тухай бүрт	Бригадын генерал Ж.Өсөхбаяр Ёс зүйн дэд хорооны гишүүд	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүд
3	Ёс зүйн хороонд ирсэн гомдол, мэдээлэл, гарсан зөрчлийн агуулга, шинж байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах	Дүн шинжилгээ хийж, тухай бүрт нь холбогдох арга хэмжээ авах	Тухай бүрт	Бригадын генерал Ж.Өсөхбаяр Ёс зүйн дэд хорооны гишүүд	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүд
Гурав.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд:					
1	Ёс зүйн дэд хороодын алба хаагчдыг чадавхжуулах сургалтад танхимаар болон цахимаар хамруулах	Хууль, тогтоомжийн хэрэгжилт, ёс зүйн талаарх бодлого, хариуцлагын тогтолцоо, төлөв байдалд үнэлгээ дүгнэлт хийх	Жилдээ	Бригадын генерал Ж.Өсөхбаяр Ёс зүйн дэд хорооны гишүүд	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүд
2	“Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт тавих, үүрэг чиглэл өгөх	“Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэд хяналт тавих, үүрэг чиглэл өгөх	Жилдээ	Бригадын генерал Ж.Өсөхбаяр Ёс зүйн дэд хорооны гишүүд	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүд

1	2	3	4	5	6
3	Ёс зүйн дүрэм, Ёс зүйн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх арга хэмжээг хэрэгжүүлэх	ЗХЖШ-ын даргын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтаар хэрэгжүүлэх	Жилдээ	Хурандаа А.Нямбаяр	ХШҮГ ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүд
4	Цаг үеийн асуудал болон төлөвлөгөөт ажлуудын хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийх, үүрэг чиглэл, заавар зөвлөмж өгөх	Үүрэг, даалгавар, заавар, зөвлөмж өгөх арга хэмжээг зохион байгуулах	Тухай бүрт	Бригадын генерал Ж.Өсөхбаяр	ЗХЖШ-ын Ёс зүйн дэд хорооны гишүүд

ТӨЛӨВЛӨСӨН:
ЗХЖШ-ЫН ЁС ЗҮЙН ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХУРАНДАА А.НЯМБАЯР